



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.02.06 № 06/88 УАГ-САГ/2012/ЗА-04

**Зөрчлийг арилгах тухай**

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2011, 2012 оны санхүүгийн зарим үйл ажиллагаанд хийсэн аудитаар Япон Улсын Засгийн газрын 2009 оны санхүүгийн жилийн "Хүнсний хангамжийг сайжруулах КР-1" төслийн буцалтгүй тусламжийн хүрээнд нийлүүлэгдсэн цагаан будааг зарим иргэн, аж ахуйн нэгжид зээлээр борлуулж, нэр бүхий 16 иргэн, аж ахуйн нэгжээс нийт 708.6 сая төгрөгийн авлага үүсгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 5.1.4-т "санхүү, төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14.1.1-д "Зээл авах, зээл олгох, зээлийн төлбөр гүйцэтгэх, зээл хувиргахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "... тухайн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байхад чухал үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдалд төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цагаан будааны үнэ 708.6 сая төгрөгийг хавсралтад дурьдсан нэр бүхий 16 иргэн, аж ахуйн нэгжээр төлүүлж, КР-1 төслийн хуримтлалын сангийн "Голомт" банкин дахь 2005001614 дүгээр дансанд 2013 оны 4 дүгээр сарын 25-ны дотор төвлөрүүлэх;
2. Хугацаандаа төлөгдөөгүй тохиолдолд "Хүнсний цагаан будааг худалдах, худалдан авах гэрээ"-ний 4.3-т заасны дагуу хууль шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэх;
3. Албан шаардлагын биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулж, 2013 оны 5 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт хариу ирүүлэхийг ТЭДС-гийн гүйцэтгэх захирал Д.Од, хуулийн зөвлөх Д.Бат-Эрдэнэ, ерөнхий нягтлан бодогч Г.Батцэцэг нарт хариуцуулав.

Санхүүгийн аудитын газрын  
Нэгдүгээр хэлтсийн захирал

С.Оюунгэрэл



Цагаан будааны авлага

		2012.07.01 нй үлдэгдэл	төлсөн	бэлнээр	2012.09.30 үлдэгдэл
1	ДББС ХХК	4,000,000			4,000,000
2	Балжинням.М	(1,000)			(1,000)
3	ББС Велт ХХК	77,000,000	70,000,000		7,000,000
4	Дашцэрэн	11,000,000			11,000,000
5	Баярсайхан.В	215,500	215,500		-
6	Баяннэмэх ХХК	53,989,000		54,051,000	(62,000)
7	Алтай саян ХХК	48,400,000			48,400,000
8	Алтай.Б	25,300,000			25,300,000
9	Алтанцоож.Р	11,000,000	3,000,000		8,000,000
10	Болорчулуун.Ц	33,000,000			33,000,000
	Гольштейн				
11	монголиа ХХК	110,000,000			110,000,000
12	Гоо мишээл ХХК	245,784,000		183,545,000	62,239,000
13	Отгонбаяр.Х	5,610,000			5,610,000
14	Сүрэнжав.Г	4,000			4,000
15	Хүүхэд асрах төв	33,000,000			33,000,000
16	Хүнс импэкс ХХК	200			200
17	Оюунчимэг Г	55,011,000			55,011,000
18	Өлзийхүү Ц	44,022,000			44,022,000
19	Амар бар	275,000,000	66,000,000		209,000,000
20	Дэлгэрмаа Б	53,100,000			53,100,000
		<b>1,085,434,700</b>	<b>139,215,500</b>	<b>237,596,000</b>	<b>708,623,200</b>

Мэдээлэл үзүүлэгч - У.Г. Урландын

